

# НОГООН БҮСИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

## НЭГ. ҮЗЭСГЭЛЭНГИЙН ПАВИЛЬОН

### 1.1 Зохион байгуулалт, зориулалт, хийцлэлийн ерөнхий тайлбар

Үзэсгэлэнгийн павильон нь Ногоон бүсийн үндсэн байгууламжийн нэг бөгөөд олон улсын оролцогч байгууллага, улс орнуудын үзэсгэлэн, танилцуулга, бүтээгдэхүүн, санаачилгыг олон нийтэд танилцуулах зориулалттай байна.

Тус павильон нь тэнхлэгийн дагуу 80.0 м × 50.0 м хэмжээтэй, барилгын дотор цэвэр талбай нь 3861.66 м<sup>2</sup> бөгөөд нэг давхар, баганагүй, чөлөөт төлөвлөлт бүхий танхим хэлбэрээр шийдэгдэнэ.

Үзэсгэлэнгийн дараах үндсэн зориулалтыг хангана:

- Оролцогч байгууллага, улс орнуудын үзэсгэлэн, танилцуулга явуулах
- Стандарт болон тусгай павильон байрлуулах
- Зочдын урсгалыг саадгүй, аюулгүй зохион байгуулах
- Танхим доторх жижиг хэмжээний арга хэмжээ, илтгэл, танилцуулга зохион байгуулах
- Амралт, уулзалт, харилцаа холбооны орчин бүрдүүлэх

### 1.2 Дотоод ерөнхий зохион байгуулалт

Үзэсгэлэнгийн павильоны дотоод зохион байгуулалт нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

#### 1.2.1. Ханын дагуух стандарт павильоны бүс

Танхимын дөрвөн талын ханын дагуу жигд хэмжээтэй стандарт павильонууд байрлана. Эдгээр павильон нь оролцогчдод түрээслэх зориулалттай бөгөөд нэг бүрчлэн угсарч, бэлэн байдлаар хүлээлгэн өгнө.

#### 1.2.2. Танхимын төв хэсгийн оролцогчдын захиалгаар гүйцэтгэх павильоны бүс

Танхимын төв хэсэгт том хэмжээтэй, захиалгат павильон байрлуулах нээлттэй талбай төлөвлөгдөнө. Энэхүү хэсэгт байрлах павильонуудыг оролцогч талын хүсэлтээр гүйцэтгэгчийн гэрээт зураг төслийн компани дизайн, төлөвлөлтийг гүйцэтгэж, гэрээт компаниар угсруулах бөгөөд тус гэрээний хүрээнд зөвхөн инженерийн суурь бэлтгэл болох цахилгаан, интернэт холболтыг хангана.

#### 1.2.3. Явган урсгалын зам

Павильоны хоорондын үндсэн болон туслах коридорууд төлөвлөгдөж, зочдын хөдөлгөөнийг аюулгүй, чөлөөтэй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.



бүрхүүлийг суурилуулах, шал, хивсэнцэр, хаалга, орц гарцын шийдлийг нэмж суурилуулах ажилбарууд хийгдэнэ.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Үндсэн байгууламж угсрах, буулгах	Урьдчилан нийлүүлэгдсэн үзэсгэлэнгийн танхимын металл каркас, багана, дам нуруу бүхий үндсэн хийцийг талбайд зөөвөрлөн угсарч, гадна бүрхүүлийг суурилуулж, арга хэмжээний дараа буулгаж, хүлээлгэж өгнө.	80.0 м × 50.0 м, S=3861.66 м <sup>2</sup>	Угсралт нь аюулгүй байдлын шаардлага хангасан байна
3	Шалны суурийн тэгшилгээ	Танхимын нийт талбайд суурийн гадаргууг няглан, шаардлагтай тохиолдолд тэгшилж, нягтруулалт хийж, хүний болон тоног төхөөрөмжийн ачаалал даахуйц суурь бэлтгэнэ.	3861.66 м <sup>2</sup>	Даацын шаардлага хангана
4	Шалны хучилт угсрах	Тэгшилсэн суурин дээр түр шалны систем угсарч, гулгамтгай бус, элэгдэлд тэсвэртэй хивсэнцэр хучилт хийж, кабелийн шугамыг далд байрлуулах нөхцөл бүрдүүлнэ	3861.66 м <sup>2</sup>	Ашиглалт, цэвэрлэгээнд тохиромжтой
5	Үндсэн орц, гарц, аюулгүйн хаалга	Үзэсгэлэнгийн танхимд зочдын урсгалыг аюулгүй, саадгүй зохион байгуулах зорилгоор тус бүр нь 3.6–4.0 м өргөн, 3.0–4.0 м өндөртэй, гадагш нээгддэг давхар далавчтай 4 үндсэн орц, гарц, мөн 1.2–1.5 м өргөнтэй 2–4 нэмэлт аврах гарцын хаалгыг босгогүй буюу нам босготойгоор суурилуулж, салхи, тоос нэвтрүүлэхгүй нягтруулгатай, яаралтай үед дотор талаас түлхэхэд шууд нээгдэх бариултай, орц бүрд нэмэлт гэрэлтүүлэг, чиглүүлэх болон аюулгүй байдлын тэмдэглэгээ, шалны урсгалын тэмдэглэгээ, салхины хамгаалалтын шийдэл, хяналтын	4ш	Аюулгүй байдлын шаардлага

		төхөөрөмж суурилуулах бэлтгэлийг бүрэн хангана.		
--	--	---	--	--

#### 1.4. Дотор зохион байгуулалт, инженерийн системийн ажилбарууд

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Явган урсгалын үндсэн зам	Танхимын зохион байгуулалтын дагуу павильон хоорондын гол урсгалын замыг төлөвлөж, шалны тэгшилгээ, хучилт, урсгалын чиглүүлэх тэмдэглэгээг хийж, зочдын хөдөлгөөнийг саадгүй, аюулгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ	4–5 м өргөн, нийт уртын дагуу	Гол хөдөлгөөний тэнхлэг
2	Туслах зам	Танхимын дотоод зохион байгуулалтын дагуу павильон хоорондын хөдөлгөөнийг дэмжих туслах замыг төлөвлөж, шалны тэгшилгээ, хучилт, урсгалын чиглүүлэх тэмдэглэгээг хийж, зочдын хөдөлгөөнийг жигд, аюулгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ	3 м өргөн, нийт уртын дагуу	Хоёрдогч урсгалын зам
3	Дотоод хаягжилт, чиглүүлэх тэмдэглэгээ	Танхимын дотоод зохион байгуулалтын дагуу павильон, өрөө, үйлчилгээний хэсэг, гарц болон үндсэн чиглэлийг заах хаягжилт, чиглүүлэх тэмдэг, байршлын самбар, шалны тэмдэглэгээг төлөвлөж суурилуулна	20–30 ширхэг	Зочдын хөдөлгөөнийг ойлгомжтой, саадгүй зохион байгуулах зорилгоор гол цэгүүдэд байрлана
4	Цахилгаан хуваарилалтын систем	Цахилгааны ачааллыг бүсчилж хуваарилах	4–6 ширхэг	Аюулгүй ажиллагааны

		самбаруудыг зургийн дагуу суурилуулна		шаардлага хангана
5	Ерөнхий гэрэлтүүлэг	Танхимын нийт орон зайг жигд гэрэлтүүлэх ерөнхий гэрлийн системийг суурилуулна	Бүрэн	Ажиллагаанд тохирсон гэрэлтүүлэг
6	Интернэт, холбооны сүлжээ	Танхимын нийт талбайд интернэт, дотоод сүлжээний холболтыг зураг, төслийн дагуу хангана	Бүрэн	Бүрэн
7	Гадна фасад	Үзэсгэлэнгийн танхимын гадна пасадыг дизайн бүхий бүрэлт, хэвлэмэл материалаар бүрнэ. Ингэхдээ фасад тогтоох рамт тулгуур шат угсарч, суурилуулна.	Нийт талбайгаар	Батлагдсан дизайнаар
8	Агааржуулалтын систем угсрах	Батлагдсан зураг төслийн дагуу үзэсгэлэнгийн танхимын дотор агааржуулалтын хоолой, шугам сүлжээг угсарч, гадна талд агааржуулалтын төхөөрөмжийг суурилуулан дотоод орчны агаарын солилцоог хангана	Танхимын нийт талбай 3861.66 м <sup>2</sup>	Агаарын жигд тархалт, хэвийн ажиллагааг хангана
9	Захиалгат павильонд инженерийн холболтын бэлтгэл хангах	зэсгэлэнгийн танхимын төв хэсэгт байрлах захиалгат павильон угсралтад зориулан цахилгаан болон интернэтийн шугам сүлжээг байршил тус бүрд хүргэж, холболтын цэгүүдийг бэлтгэнэ.	Байршлын төлөвлөлтийн дагуу	Павильон угсралтын гүйцэтгэгчид шууд холбогдох боломжтой байна

### 1.5. Арга хэмжээний тайзны зохион байгуулалт

Үзэсгэлэнгийн танхимын төв хэсэгт байрлах тайзны бүс нь илтгэл, хэлэлцүүлэг, танилцуулга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үндсэн орон зай байна. Тайзны бүс нь нийт 493.24 м<sup>2</sup> талбайг хамарч, тайзны платформ, үзэгчдийн суудлын зохион байгуулалт, техникийн удирдлагын хэсэг болон дуу, гэрэл, дүрс, орчуулгын иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдана.

Тус бүс нь олон төрлийн арга хэмжээг тасралтгүй, найдвартай явуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд дуу, дүрсний чанар, харагдах байдал, аюулгүй ажиллагаа, зочдын хөдөлгөөний зохион байгуулалтыг бүрэн хангахуйц байдлаар төлөвлөгдөнө.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Тайзны байгууламж	Үзэсгэлэнгийн танхим дотор арга хэмжээ, илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулах зориулалттай тайзны платформыг металл каркас бүхий хийцтэйгээр угсарч, дээр нь гулгамтгай бус хивсэнцэр шал хийж, панелист суух, илтгэл тавих, тоног төхөөрөмж байрлуулах нөхцөлийг бүрдүүлнэ	60–80 м <sup>2</sup>	Даацын шаардлага хангасан, тогтвортой, олон төрлийн арга хэмжээнд ашиглах боломжтой
2	Суудлын бүс	Тайзны өмнө үзэгчдийн суудлыг стандартын дагуу байрлуулж, эгнээ хоорондын зай, хөдөлгөөний гарцыг төлөвлөн зохион байгуулна	193 суудал	Аюулгүй нэвтрэх гарц, урсгалын зохион байгуулалттай
3	Кабелийн зохион байгуулалт	Тайз болон суудлын бүсэд шаардлагатай цахилгаан, дуу, дүрсний шугам сүлжээг далд, хамгаалалттайгаар зохион байгуулж, кабелийн гарц, суваг, холболтыг бэлтгэнэ	Далд, цэгцтэй холболттой байна.	Ил задгай кабельгүй, бүдэрч унах эрсдэлгүй
4	Дууны систем	Тайзны арга хэмжээнд зориулсан дуу өсгөгч, микрофон, чанга яригч, удирдлагын төхөөрөмжийг суурилуулж, танхимын бүх хэсэгт жигд сонсогдох нөхцөлийг бүрдүүлнэ	Суурин болон утасгүй микрофон нийт 8–10 ширхэг, хөгжмийн хүчин чадал нь 192 суудлын хамрах хүрээг хамрахаар	Илтгэл, хэлэлцүүлэг, хөгжмийн арга хэмжээнд тохиромжтой

5	Гэрэлтүүлгийн систем	Тайз болон илтгэгчийн бүсийг гэрэлтүүлэх зориулалттай гэрэлтүүлгийн төхөөрөмжийг суурилуулж, гэрлийн түвшин, чиглэл, тохиргоог удирдах боломжтой байна.	Бүрэн	Тайз тод харагдах, бичлэг хийх боломжтой
6	Дэлгэцийн систем	Илтгэл, танилцуулга үзүүлэх зориулалттай дэлгэц, холбогдох төхөөрөмжийг суурилуулна	1–2 иж бүрдэл: 4.0–5.0 м × 2.5–3.0 м	Танхимын бүх суудлаас тод харагдах
7	Удирдлагын хэсэг	Дуу, гэрэл, дүрсний тоног төхөөрөмжийг удирдах хяналтын хэсгийг зохион байгуулна	1 хэсэг	Удирдлагын хэсэг тайзны ард эсвэл хажууд байрлах ба техникийн ажилтанд зориулсан ширээ, хаалттай байна.
8	Орчуулгын бүхээг	Монгол-англи хэлний синхрон орчуулга хийх зориулалттай дуу тусгаарлалттай бүхээгийг байрлуулна	2 ширхэг	Тайзны орчимд байрлана
9	Орчуулгын систем	Орчуулгын дамжуулах, хүлээн авах системийг суурилуулна. Үзэгчдэд зориулсан орчуулга сонсох чихэвчийг нийлүүлнэ	200 ширхэг чихэвч, 2 хэлний орчуулгын бүүт байршуулна.	Дууны системтэй уялдсан байна.
10	Тайзны буйдан	Тайзан дээр панелистууд суух тохойвчтой, нэг хүний буйдан сандал	8 ширхэг	Хөдөлгөх боломжтой, өнгө, дизайны хувьд зөвшилцөх
11	Тайзны ширээ	Хурлын панелистууд ашиглах намхан тайзны ширээ	4 ширхэг	Хөдөлгөх боломжтой, өнгө, дизайны хувьд зөвшилцөх

## 1.6. Хана дагасан стандарт павильон суурилуулах

Үзэсгэлэнгийн танхимын ханын дагуу байрлах 42 × 25 м<sup>2</sup>, нийт 1050 м<sup>2</sup> орчим талбайд хийгдэх стандарт павильонуудыг гүйцэтгэгч нэг ижил хэмжээ, хийц, өнгө төрх, техникийн шаардлагын дагуу нийлүүлж, угсарч, суурилуулна. Стандарт павильон бүр нь оролцогч байгууллага, улс орны нэр, дугаар байрлуулах хаягийн хэсэгтэй, үндсэн гэрэлтүүлэг, цахилгааны холболт, интернэт холболтын бэлтгэлтэй байна.

Павильоны үндсэн хийц, хана, хаягжилт, суурь дэд бүтцийг гүйцэтгэгч хариуцах бөгөөд павильон доторх нэмэлт тохижилт, үзүүлэн, тавилга, сурталчилгааны материал, дэлгэц, бүтээгдэхүүн байршуулалт зэрэг нь оролцогч талын хариуцлага байна.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Стандарт павильон нийлүүлж, угсрах	Үзэсгэлэнгийн танхимын ханын дагуу байрлах стандарт павильонуудыг нэг ижил загвар, хэмжээ, хийцийн дагуу нийлүүлж, угсарч, ашиглалтад бэлэн болгоно	42 ширхэг, нэг бүр нь 5.0 м × 5.0 м, 3 талын ханатай байна.	Эцсийн тоо батлагдсан зохион байгуулалтын зургаар тодорхойлогдоно. Нүүрэн тал нь нээлттэй байна
2	Павильоны үндсэн хийц угсрах	Павильон бүр даацын хөнгөн хийц, тулгуур, холбох эд анги, хүрээг угсарна	42 иж бүрдэл	Угсралт нь бат бөх, хөдөлгөөнд тэсвэртэй, ашиглалтын явцад хэлбэр алдагдахгүй байна
3	Хаяг байрлуулах хэсэг хийх	Павильон бүрийн нүүрэн хэсэгт оролцогчийн нэр, дугаар, лого байрлуулах зориулалттай хаягийн самбар суурилуулна	Павильон бүрд 1 ширхэг	Хаягийн хэвлэл, агуулгыг оролцогч тал өгнө.
4	Үндсэн гэрэлтүүлэг суурилуулах	Павильон бүрийн дотор үзүүлэн, танилцуулга байрлуулахад хангалттай гэрэлтүүлгийг суурилуулна	Павильон бүрд 2–4 гэрлийн цэг	Гэрэлтүүлгийн тоо павильоны эцсийн загвараар баталгаажна.
5	Цахилгааны холболт хийх	Павильон бүрд цахилгааны хэрэглээний үндсэн цэг гаргаж, хамгаалалттай залгуур, холболтыг суурилуулна	Павильон бүрд 2–4 залгуурын цэг	Ил задгай, хамгаалалтгүй кабель байршуулахгүй

6	Интернэт холболтын бэлтгэл хийх	Павильон бүрд интернэт холболтын суурь шугам, холболтын цэгийг бэлтгэнэ.	Павильон бүрд холболтын цэг 1	Идэвхжүүлэлт, хэрэглээний нөхцөлийг зохион байгуулагчийн шийдвэрээр тогтооно
7	Кабелийн хамгаалалт хийх	Павильон руу орох цахилгаан, интернэтийн шугамыг хамгаалалтын суваг, далд эсвэл аюулгүй байрлалаар шийднэ	Бүх павильонд	Хүн бүдрэх, кабель гэмтэх эрсдэлийг арилгана

### 1.7. Кофе шопны талбайн хэсэг

Үзэсгэлэнгийн танхим дотор зочид, оролцогчдод кофе, ундаа, хөнгөн хоолны үйлчилгээ үзүүлэх зориулалттай 238.54 м<sup>2</sup> талбай бүхий үйлчилгээний бүс байгуулна. Тус бүс нь үйлчилгээний лангуу, суудлын хэсэг, тоног төхөөрөмжийн байршуулалт, цахилгаан болон усны холболт, хог хаягдлын зохион байгуулалтаар хангагдсан, зочдын урсгалд саад учруулахгүй, түргэн шуурхай үйлчлэх нөхцөлтэй байна.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Кофе шопын бүсийн зохион байгуулалт	Батлагдсан төлөвлөлтийн дагуу кофе шопын үйлчилгээний хэсэг, суудлын бүс, хөдөлгөөний урсгалыг иж бүрнээр нь зохион байгуулна	238.54 м <sup>2</sup>	Зочдын урсгалд саад учруулахгүй
2	Үйлчилгээний лангуу угсрах	Кофе, ундаа бэлтгэх, үйлчлэх зориулалттай лангуу, ажлын тавцанг угсарч байрлуулна	1 иж бүрдэл	Ус, цахилгаан холболттой уялдана
3	Суудлын хэсэг байгуулах	Зочдын сууж үйлчлүүлэх суудал, ширээг байрлуулна	56 сандал	Түргэн эргэлттэй ашиглалт
4	Хоол, ундааны тоног төхөөрөмж	Кофе машин, хөргөгч, хөлдөөгч, жижиг төхөөрөмжүүдийг байрлуулж, холболтыг бэлтгэнэ	Иж бүрэн	Ашиглалтын шаардлага хангана
5	Цахилгааны холболт	Тоног төхөөрөмжийн цахилгаан хэрэглээнд зориулсан	Бүрэн	Ачаалал даах чадвартай

		холболтын цэгүүдийг суурилуулна		
6	Усны шийдэл	Кофе шопын үйл ажиллагаанд шаардлагатай ус хангамжийн холболтыг бэлтгэнэ	Бүрэн	Ариун цэвэр, ашиглалтын шаардлага
7	Интернэт холболт	Кассын систем болон үйлчилгээний үйл ажиллагаанд шаардлагатай интернэтийн холболтыг хангана	Бүрэн	Төлбөр тооцоонд ашиглана
8	Хог хаягдлын шийдэл	Хог хаягдлыг ангилан ялгах сав байрлуулна	4–6 ширхэг	Цэвэр байдлыг хангана
9	Байршлын тэмдэглэгээ	Кофе шопын байршлыг заах хаяг, тэмдэглэгээ байрлуулна	Бүрэн	Зочдод ойлгомжтой

### 1.8. Нийтийн талбайн тохижилт, орчны бүрдүүлэлт

Үзэсгэлэнгийн танхимын дотоод зохион байгуулалтад зочдын хөдөлгөөн, аюулгүй байдал, үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор нийтийн талбай болон коридорын системийг төлөвлөсөн. Коридор, явган урсгалын замууд нь нийт 1550.79 м<sup>2</sup> талбайг хамарч, танхимын нийт талбайн ойролцоогоор 40 хувь-ийг эзэлж байна.

Энэхүү бүс нь павильон хоорондын үндсэн болон туслах зам, тайз болон үйлчилгээний хэсгүүдийг холбох хөдөлгөөний тэнхлэг, амралтын болон уулзалтын задгай талбайгаас бүрдэх бөгөөд зочдын урсгалыг саадгүй, ойлгомжтой зохион байгуулах, аюулгүй нэвтрэх нөхцөлийг хангах үндсэн үүрэгтэй.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Нийтийн талбайн орчны тохижилт	Үзэсгэлэнгийн танхимын нийтийн талбайд (коридор, амралтын бүс, тайз орчим) орчны гоо зүй, тав тухыг нэмэгдүүлэх зорилгоор тохижилт, чимэглэл, ногоон элемент, интерьерийн зөөлөн шийдлүүдийг төлөвлөж байрлуулна	Танхимын нийт нийтийн талбайд	Нэгдсэн дизайн, өнгө төрхийг хангана

2	Ногоон элемент (ургамал) байрлуулах	Нийтийн талбайд дотоод орчны ургамал, ногоон чимэглэлийг байрлуулна	20–40 элемент	Ногоон орчин бүрдүүлнэ
3	Амралтын нэмэлт элемент	Сандал, зөөлөн тохижилт, жижиг интерьер элементүүдийг байрлуулна	Бүрэн	Тав тух нэмэгдүүлнэ
4	Чимэглэлийн элемент	Брэндингтэй уялдсан дотоод чимэглэл, инсталляц, гоёлын элементүүдийг байрлуулна	Бүрэн	Үзэсгэлэнгийн өнгө төрх бүрдүүлнэ
5	Гэрэлтүүлгийн чимэглэл	Нийтийн талбайд гоёлын зориулалттай нэмэлт гэрэлтүүлгийг суурилуулна	Бүрэн	Орчны уур амьсгал бүрдүүлнэ

### 1.9. Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий агуулах

Үзэсгэлэнгийн танхимын үйл ажиллагааг дэмжих зорилгоор тоног төхөөрөмж, материал, хэрэглэгдэхүүн, нөөцийг хадгалах, түр байршуулахад зориулсан **3 ширхэг агуулахын хэсгийг** зургийн дагуу төлөвлөж байгуулна.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Агуулахыг байр төлөвлөх	Батлагдсан зохион байгуулалтын дагуу агуулахын байршлыг тогтоож, бусад үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна		Үйл ажиллагаанд саад учруулахгүй байрлал
2	Агуулахын хийц угсрах	Агуулахын хана, хаалт, хаалга бүхий үндсэн хийцийг төлөвлөгдсөн байршилд угсарч, тусгаарласан орон зай бүрдүүлнэ	Тус бүр 31.2м <sup>2</sup> хэмжээтэй 3 ширхэг	Аюулгүй, хаалттай орчин
3	Хаалга, түгжээ суурилуулах	Агуулах бүрд нэвтрэх хаалга, түгжээ, хамгаалалтын шийдлийг суурилуулна	3 ширхэг	Хяналт, хамгаалалтын шаардлага хангана

4	Цахилгааны холболт	Агуулах дотор гэрэлтүүлэг болон шаардлагатай цахилгааны холболтыг бэлтгэнэ	Бүрэн	Ашиглалтын нөхцөлийг хангана
5	Тавиур, хадгалалтын шийдэл	Материал, тоног төхөөрөмж байрлуулах тавиур, хадгалалтын энгийн шийдлийг байрлуулна	3 агуулах	Ашиглалтын үр ашиг нэмэгдүүлнэ
6	Аюулгүй байдлын нөхцөл	Агуулахын орчинд галын болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангана	Бүрэн	Галын эрсдэлээс сэргийлнэ
7	Тэмдэглэгээ	Агуулахын байршил, зориулалтыг заах тэмдэглэгээ байрлуулна	Бүрэн	Танигдахуйц, ойлгомжтой

#### 1.10. Тоног төхөөрөмж, тавилга

Үзэсгэлэнгийн танхим доторх тайзны бүс, кофе шоп, нийтийн талбайд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулна. Тоног төхөөрөмж нь үзэсгэлэн, үйлчилгээ, арга хэмжээний үйл ажиллагааг хэвийн явуулах, зочдын тав тухыг хангах, ашиглалтын аюулгүй байдлыг бүрдүүлэх шаардлагад нийцсэн байна.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Хурлын хэсгийн сандал	Хурлын зааланд ашиглах стандарт сандлуудыг нийлүүлж байрлуулна	193 ширхэг	Хурлын сандал
2	Хоолны заалны сандал	Кофе шоп, үйлчилгээний хэсэгт ашиглах өндөр сандал байрлуулна	56 ширхэг	Лангууны зориулалттай
3	Ширээ	Кофе шоп болон нийтийн талбайд ашиглах ширээнүүдийг байрлуулна	12 ширхэг	Стандарт хэмжээ
4	Дугуй ширээ	Уулзалт, амралтын зориулалттай дугуй ширээ байрлуулна	14 ширхэг	d≈2000 мм
5	Буйдан	Амралтын бүс, кофе шопын хэсэгт зөөлөн суудал байрлуулна	48 ширхэг	Тав тух нэмэгдүүлнэ

6	Хөргөгч	Хоол, ундаа хадгалах зориулалттай хөргөгч суурилуулна	8 ширхэг	Кофе шопын хэрэглээ
7	Кофе чанагч машин	Кофе бэлтгэх зориулалттай төхөөрөмжийг байрлуулна	8 ширхэг	Үйлчилгээний хэсэг
8	Кассын төхөөрөмж	Төлбөр тооцооны төхөөрөмжийг суурилуулна	4 ширхэг	Интернэт холбоно.
9	Тавцан ширээ	Үйлчилгээний лангуу, ажлын тавцанг байрлуулна	4 ширхэг	Кофе шопны хэсэг
10	Лангуу	Үйлчилгээний үндсэн лангууг угсарч байрлуулна	4 ширхэг	Төхөөрөмж байрлуулах
11	Хөлдөөгч	Хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөлдөөгч байрлуулна	4 ширхэг	Кофе шоп
12	Ус буцалгагч	Ус халаах төхөөрөмжийг суурилуулна	20л, 6 ширхэг	Нийтийн талбайд оролцогчдын хэрэгцээнд
13	Гар утас цэнэглэх төхөөрөмж	Нийтийн талбайд гар утас цэнэглэх станц байрлуулна	38 ширхэг	Зочдын хэрэглээ

## ХОЁР. ХҮЛЭЭН АВАЛТЫН ТАНХИМ (EVENT HALL)

### 2.1. Зохион байгуулалт, зориулалт, хийцлэлийн ерөнхий тайлбар

Хүлээн авалтын танхим нь Ногоон бүсийн хүрээнд зохион байгуулагдах албан ёсны хүлээн авалт, уулзалт, хоол, арга хэмжээ, нетворкинг үйл ажиллагаанд зориулсан, олон зориулалтын орон зай байна.

Тус танхим нь 50.0 м × 20.0 м хэмжээтэй, нийт 975.67 м<sup>2</sup> талбай бүхий нэг давхар, чөлөөт зохион байгуулалттай байх бөгөөд суудлын болон зогсолтын арга хэмжээг хослуулах боломжтой байдлаар төлөвлөгдөнө.

Танхим нь дараах үндсэн үйл ажиллагааг хангана:

- Албан ёсны хүлээн авалт, уулзалт зохион байгуулах
- Хоол, үйлчилгээний үйл ажиллагаа явуулах
- Зочдын чөлөөт уулзалт, нетворкинг орчныг бүрдүүлэх
- Жижиг хэмжээний илтгэл, тайзтай арга хэмжээ зохион байгуулах боломжтой.

## 2.2. Дотоод ерөнхий зохион байгуулалт


Хүлээн авалтын танхимын дотоод зохион байгуулалт нь зочдын үйлчилгээ, арга хэмжээний урсгал, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор нэгдсэн байдлаар төлөвлөгдөнө.

Тус зохион байгуулалт нь үндсэн хүлээн авалтын бүс, хоол үйлчилгээний бүс, хадгалалт, ажилтны болон туслах өрөөнүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь хоорондоо уялдаа холбоотой, урсгал давхцахгүй, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байна.

Хүлээн авалтын танхим нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Үндсэн хүлээн авалтын бүс (~871.89 м<sup>2</sup>)
- Тайз болон илтгэлийн бүс
- Үйлчилгээний бүс (гал тогоо 58.05 м<sup>2</sup>, бар - 9.64 м<sup>2</sup>)
- Хүйтэн (12.28 м<sup>2</sup>) болон бараа материалын агуулах, бэлтгэлийн өрөө - (12.58 м<sup>2</sup>)
- Ажилтнуудын өрөө - 11.23 м<sup>2</sup>
- Нийтийн талбай, зочдын урсгал, коридор

### EVENT HALL 1000M2



/Зураг 2. Хүлээн авалтын танхимын ерөнхий төлөвлөлт/

## 2.3. Үндсэн барилгын угсралтын ажил

Хүлээн авалтын танхимын түр байгууламжийг гүйцэтгэгч өөрийн шийдлээр нийлүүлж, талбайд угсарч, ашиглалтад бэлтгэн, арга хэмжээний хугацаанд хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж, дууссаны дараа буулгаж зайлуулах ажлыг бүрэн хариуцна.

Тус байгууламж нь металл каркас бүхий бат бөх хийцтэй, хана болон дээврийн бүрхүүлтэй, дотор ашиглалтын орчныг бүрдүүлэх иж бүрэн шийдэлтэй байх бөгөөд дотоод зохион байгуулалт, инженерийн систем, шалны угсралт, хучилт, хаалга, орц гарц, фасад, тоноглол зэргийг цогцоор нь шаардлагын дагуу нийлүүлнэ.

Гүйцэтгэгч нь барилгын хийц, материал, угсралтын технологи, аюулгүй байдал, ашиглалтын нөхцөлийг бүрэн хариуцаж, зураг төсөл болон техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Үндсэн байгууламж нийлүүлэх, угсрах, буулгах	Металл каркас, багана, дам нуруу, холболтын зангилаа бүхий үндсэн хийцлэлтэй, хана болон дээврийн бүрхүүлийг ПВХ мембран материалаар бүрсэн байгууламжийг гүйцэтгэгч нийлүүлж, талбайд угсарч, бэхэлгээ, тогтворжилтыг ханган ашиглалтын хугацаанд аюулгүй ажиллагааг хангаж, арга хэмжээ дууссаны дараа буулгана.	50.0 × 20.0 м, S=975.67 м <sup>2</sup>  ПВХ мембран 650–900 гр/м <sup>2</sup>	Олон нийтийн ачаалал даах чадвартай байх ба ус, салхи, тоос нэвтрэхгүй битүү орчныг бүрдүүлнэ.
2	Шал тэгшилгээ	Барилгын дотор талбайн суурийг тэгшилж, нягтруулалт хийж, хүний болон тоног төхөөрөмжийн ачаалал даах нөхцөлийг бүрдүүлнэ	975.67 м <sup>2</sup>	Даацын шаардлага хангана
3	Шалны хучилт	Тэгшилсэн суурин дээр түр шалны систем угсарч, гулгамтгай бус, элэгдэлд тэсвэртэй, цэвэрлэгээ хийхэд хялбар хивсэнцэрээр хучилтыг гүйцэтгэнэ	975.67 м <sup>2</sup>	Кабелийн далд шийдэлтэй байна
4	Хаалга, орц, гарц	Танхимын үндсэн болон нэмэлт орц, гарцыг гадагш нээгддэг, босгогүй буюу нам босготой, 3.6–4.0 м өргөн, 3.0–4.0 м өндөртэй, аюулгүй ажиллагааны шаардлага	2–4 орц, 1–2 аврах гарц	Хаалга, орц, гарц нь яаралтай үед дотор талаас түлхэхэд шууд нээгдэх бариултай, орц бүрд нэмэлт гэрэлтүүлэг,

		хангасан хаалгаар шийдвэрлэнэ		чиглүүлэх болон аюулгүй байдлын тэмдэглэгээ, хяналтын төхөөрөмж суурилуулах бэлтгэлийг бүрэн хангасан байна.
5	Ерөнхий гэрэлтүүлэг	Танхимын дотор орчныг жигд гэрэлтүүлэх үндсэн гэрэлтүүлгийн системийг суурилуулна	Бүрэн	Арга хэмжээний шаардлага хангана
6	Гадна фасад	Барилгын гадна талд өнгө төрхийг бүрдүүлэх фасадыг суурилуулна. Фасадыг суурилуулахдаа хэвлэмэл материалыг бэхлэх рамт металл каркас хийцийг угсарч суурилуулна	Нийт гадна талбайгаар	Хэвлэмэл материалыг батлагдсан дизайны дагуу хийж гүйцэтгэх бөгөөд салхины ачаалал даах чадвартай байна.

#### 2.4. Хүлээн авалтын танхимын дотоод функциональ бүс

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Үндсэн хүлээн авалтын бүс	Дугуй ширээ, суудлын зохион байгуулалтыг хийж, зочдын хүлээн авалт, арга хэмжээ явуулах орчныг бүрдүүлнэ	~871.89 м <sup>2</sup>	300–400 хүний багтаамж
2	Гал тогооны бүс	Хоол бэлтгэх, халаах, түр хадгалах зориулалтын ажлын бүсийг байгуулж, тоног төхөөрөмж байрлуулах нөхцөлийг бүрдүүлнэ	58.05 м <sup>2</sup>	Үйлчилгээний урсгалтай уялдана
3	Баар үйлчилгээний хэсэг	Ундаа, кофе, хөнгөн үйлчилгээ үзүүлэх баарны хэсгийг байгуулна	9.64 м <sup>2</sup>	Зочдын бүстэй холбогдоно
4	Хүйтэн агуулах	Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалттай хөргөлтийн бүсийг бүрдүүлнэ	12.58 м <sup>2</sup>	Эрүүл ахуйн шаардлага хангасан.

5	Ажилтнуудын өрөө	Үйлчилгээний ажилтанд зориулсан амрах, бэлтгэл хийх орчныг бүрдүүлнэ	11.23 м <sup>2</sup>	Зочдоос тусгаарлагдсан
6	Агуулах	Материал, тоног төхөөрөмж байрлуулах тавиур, хадгалалтын энгийн шийдлийг байрлуулна. Агуулах дотор гэрэлтүүлэг болон шаардлагатай цахилгааны холболтыг бэлтгэнэ.	12.28 м <sup>2</sup>	Агуулахын орчинд галын болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангана

## 2.5. Тайз, арга хэмжээний бүс

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
7	Тайзны байгууламж	Хүлээн авалтын танхимд илтгэл, үг хэлэх, үйл ажиллагаа зохион байгуулах зориулалттай металл каркас бүхий бат бөх хийцтэй тайз угсарч, дээр нь гулгамтгай бус шалны хучилт хийж, илтгэгч болон тоног төхөөрөмж байрлуулах нөхцөлийг бүрдүүлнэ. Нийт талбай ойролцоогоор 49.8 м <sup>2</sup>	9900×5030 мм, 1 ширхэг	Даацын шаардлага хангасан, тогтвортой
8	Дууны систем	Тайз болон танхимын бүх хэсэгт жигд сонсогдохуйц дууны системийг суурилуулж, микрофон, чанга яригч, өсгөгч, удирдлагын төхөөрөмжийг иж бүрнээр байрлуулна	6–10 микрофон, бүрэн систем	Илтгэл, хөгжмийн хэрэглээнд тохиромжтой
9	Тайзны гэрэлтүүлгийн систем	Тайз, илтгэгч болон арга хэмжээний бүсийг тодруулан гэрэлтүүлэх зориулалттай гэрэлтүүлгийн төхөөрөмжийг суурилуулж, гэрлийн чиглэл, хүч, тохиргоог удирдах боломжтой байна	Бүрэн	Зураг, бичлэг хийхэд тохиромжтой

10	Дэлгэцийн систем	Танилцуулга, дүрс, мэдээлэл үзүүлэх зориулалттай дэлгэц болон холбогдох төхөөрөмжийг суурилуулна	1 ширхэг (ойролцоогоор 3–4 м өргөн)	Бүх суудлаас харагдах байрлалд
11	Налуу зам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан	~7.18 м урт	1 ширхэг

## 2.6. Дотоод зохион байгуулалт, инженерийн систем, хаягжилт

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Ерөнхий цахилгаан хангамж	Танхимын бүх бүсэд цахилгааны үндсэн хангамж, холболтыг бэлтгэнэ. Ачааллыг бүсчилж хуваарилах самбар, хамгаалалтын шийдлийг суурилуулна	Бүрэн, 2–4 ширхэг хуваарилах самбар	Тоног төхөөрөмжийн хэрэглээнд
2	Кабелийн шугам сүлжээ	Танхим доторх цахилгаан, дуу, дүрсний кабелийг далд, хамгаалалттайгаар татаж, холболтыг гүйцэтгэнэ	Бүрэн	Ил задгай кабельгүй
3	Интернэт, холбооны сүлжээ	Дотоод сүлжээ, интернэт холболтыг танхимын бүх бүсэд хүргэнэ	Бүрэн	Касс, үйлчилгээ, арга хэмжээ
4	Ерөнхий гэрэлтүүлгийн систем	Танхимын дотор орчныг жигд гэрэлтүүлэх гэрлийн системийг суурилуулна	Бүрэн	Үйл ажиллагаанд тохирсон
5	Агааржуулалтын хоолойн угсралт	Батлагдсан зураг төслийн дагуу танхимын дотор агааржуулалтын хоолой, шугам сүлжээг угсарч, агаарын жигд тархалтыг хангана	Нийт талбайд	Агаарын солилцоо жигд
6	Гадна HVAC төхөөрөмж суурилуулах	Агааржуулалт, агаарын солилцооны системийг хангах зориулалттай төхөөрөмжийг барилгын гадна талд суурилуулж, дотоод системтэй холбож ажиллуулна	Бүрэн	Найдвартай ажиллагаа

7	Дотоод хаягжилт (signage), Аюулгүй байдлын тэмдэглэгээ	Танхимын доторх бүсүүд, өрөө, үйлчилгээний хэсэг, аюулгүйн гарц, чиглүүлэх тэмдэглэгээ, ерөнхий зохион байгуулалтын зураг бүхий мэдээллийн самбарыг төлөвлөж суурилуулна	10–20 ширхэг	Гол зангилаа цэгүүдэд, зочдод ойлгомжтой байхаар.
8	Цэвэр, бохир усны холболт	Хүлээн авалтын танхим (Event hall)-ын ус хангамж, ариутгах татуургын системийг зураг төслийн дагуу гүйцэтгэж, 1-р худгаас цэвэр ус татах, бохир усыг төвлөрсөн шугамд холбох, шаардлагатай шугам хоолой, холболтын зангилаа, хаалт, хяналтын худгийг иж бүрнээр суурилуулна	Бүрэн	Гал тогоо, угаалга, ариун цэврийн хэрэгцээг хангана

## 2.7. Тоног төхөөрөмж, тавилга (FF&E)

Хүлээн авалтын танхимд ашиглагдах тавилга, тоног төхөөрөмжийг нийлүүлж байрлуулан, арга хэмжээний форматаас хамааран уян хатан зохион байгуулалт хийх боломжийг бүрдүүлнэ. Бүх эд зүйлс нь бат бөх, цэвэрлэхэд хялбар, олон нийтийн хэрэглээнд тохирсон байна.

### 2.7.1 Гал тогоо, үйлчилгээний бүс

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Хөргөгч (4 хаалгатай)	Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалттай	1200×660×1900 мм, 220V	3 ширхэг
2	Тавиур	Хүнс, хэрэгсэл хадгалах	1200×450×1550 мм	4 ширхэг
3	Угаалтуур	Гал тогооны угаах хэсэг	1800×800×860 мм	2 ширхэг
4	Зөөврийн ажлын ширээ	Хоол бэлтгэх зориулалттай	1200×800×800 мм	2 ширхэг
5	Аяга таваг угаагч	Автомат угаагч	500×450×715 мм, 0.7 кВт	1 ширхэг
6	Халаах төхөөрөмж	Хоол халаах зориулалттай	450×430×500 мм, 0.5 кВт	2 ширхэг
7	Ус буцалгагч	Халуун ус бэлтгэх	250×250×360 мм, 6 кВт, 380V	2 ширхэг

8	Хогийн сав	Хог хаягдал хадгалах	600×600×700 мм	2 ширхэг
9	Дээжний хөргөгч	Хүнсний аюулгүй байдлын үүднээс дээж хадгалах хөргөгч	450×450×500 мм	2 ширхэг

### 2.7.2 Үндсэн танхим (Event Hall)

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Тайзны буйдан	Панелист суудал	Стандарт	8 ширхэг
2	Тайзны ширээ	Тайзны зориулалттай	1600×550 мм	4 ширхэг
3	Сандал	Зочдын суудал	Стандарт	416 ширхэг
4	Өндөр сандал	Бар, үйлчилгээний зориулалттай	Стандарт	6 ширхэг
5	Дугуй ширээ	Хүлээн авалтын ширээ	d=1000 мм	20 ширхэг
6	Том дугуй ширээ	Үндсэн ширээ	d=2000 мм	20 ширхэг
7	Тэгш өнцөгт ширээ	Үйлчилгээний ширээ	1200×400 мм	17 ширхэг
8	Компьютер	Хурлын үеэр тайзан дээр ашиглагдах компьютер	Стандарт	1 ширхэг

### 2.7.3 Туслах өрөө

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Оффис сандал	Ажилтны өрөө	Дугуйтай	1 ширхэг
2	Буйдан	Амрах хэсэг	3 хүний	1 ширхэг
3	Тавиур	Хадгалалт	1200×600×2400 мм	2 ширхэг
4	Ширээ	Ажилтны ширээ	1600×600 мм	1 ширхэг
5	Зөөврийн уртасгагч	Цахилгааны сунгагч	4 оролттой	1 ширхэг

## ГУРАВ. ШИНЖЛЭХ УХААН, ОЛОН НИЙТИЙН ПАВИЛЬОН

### 3.1. Ерөнхий зориулалт, зохион байгуулалт

Шинжлэх ухаан, олон нийтийн павильон нь олон нийтэд зориулсан танин мэдэхүйн үзэсгэлэн, шинжлэх ухааны интерактив туршилт, танилцуулга, хэлэлцүүлэг, сургалт, нетворкинг үйл ажиллагааг зохион байгуулах зориулалттай олон үйлдэлт орон зай байна.

Тус павильон нь үзэсгэлэн, интерактив лаборатори, илтгэлийн танхим, уулзалтын өрөө, олон нийтийн оролцооны бүсүүдийг нэгтгэсэн нэгдсэн зохион байгуулалттай байна.

Шинжлэх ухаан, олон нийтийн зориулалттай павильон нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

<b>№</b>	<b>Бүс</b>	<b>Талбай</b>
1	Үүд, орц	69.07 м <sup>2</sup>
2	Лобби	327.32 м <sup>2</sup>
3	Кофе шоп	53.33 м <sup>2</sup>
4	Оффис	35.36 м <sup>2</sup>
5	Агуулах	43.86 м <sup>2</sup>
6	Үзэсгэлэнгийн бүс	127.47 м <sup>2</sup>
7	Нетворкинг бүс	156.53 м <sup>2</sup>
8	Илтгэлийн танхим	234.26 м <sup>2</sup>
9	Интерактив лаборатори 1	174.47 м <sup>2</sup>
10	Интерактив лаборатори 2	102.67 м <sup>2</sup>
11	Уулзалтын өрөө	29.61 м <sup>2</sup>
12	Семинар / workshop өрөө	88.51 м <sup>2</sup>



### 3.2. Үндсэн барилгын ажил

Шинжлэх ухаан, олон нийтийн павильоны үндсэн түр байгууламжийг гүйцэтгэгч өөрийн нөөц, шийдлээр нийлүүлж, талбайд угсарч, ашиглалтад бэлтгэн, арга хэмжээний хугацаанд хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж, дууссаны дараа буулгаж зайлуулах ажлыг бүрэн хариуцна.

Тус байгууламж нь тэнхлэгээрээ 50.0 м × 30.0 м, барилгын дотор цэвэр талбай S=1442.46 м<sup>2</sup> талбайтай металл каркас бүхий бат бөх хийцтэй, хана болон дээврийн бүрхүүл нь ПВХ мембран материалаар хийгдсэн, дотор орчныг бүрэн хаасан, олон нийтийн арга хэмжээ, үзэсгэлэн, танилцуулга, сургалт, интерактив үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах иж бүрэн шийдэлтэй байна.

№	Ажил	Тодорхойлолт	Үзүүлэлт	Тайлбар
1	Үндсэн байгууламж нийлүүлэх, угсрах, буулгах	Металл каркас, багана, дам нуруу, холболтын зангилаа бүхий үндсэн хийцлэлтэй, хана болон дээврийн бүрхүүлийг ПВХ мембран материалаар бүрсэн байгууламжийг гүйцэтгэгч нийлүүлж, талбайд угсарч, бэхэлгээ, тогтворжилтыг	50.0 × 30.0 м, S=1442.46 м <sup>2</sup> ; ПВХ мембран 650–900 гр/м <sup>2</sup>	Олон нийтийн ачаалал даах чадвартай, ус, салхи, тоос нэвтрэхгүй битүү орчныг бүрдүүлнэ

		ханган ашиглалтын хугацаанд аюулгүй ажиллагааг хангаж, арга хэмжээ дууссаны дараа буулгана		
2	Шал тэгшилгээ	Барилгын дотор талбайн суурийг тэгшилж, нягтруулалт хийж, хүний болон тоног төхөөрөмжийн ачаалал даах нөхцөлийг бүрдүүлнэ	1442.46 м <sup>2</sup>	Даацын шаардлага хангана
3	Шалны хучилт	Тэгшилсэн суурин дээр түр шалны систем угсарч, гулгамтгай бус, элэгдэлд тэсвэртэй, цэвэрлэгээ хийхэд хялбар хивсэнцэр хучилтыг гүйцэтгэнэ	1442.46 м <sup>2</sup>	Кабелийн шугам сүлжээг далд байрлуулах боломжтой
